

“Мөнх” гэдэг үгийн үнэн утга учир: «Шинэ гэрээ»-нд

«Хуучин гэрээ»-нд “мөнх” гэсэн үг хэрхэн хэрэглэгддэгийг авч үзсэний дараа одоо грек хэлээр бичигдсэн «Шинэ Гэрээ»-г авч үзье. «Шинэ Гэрээ»-ний үг хэллэг «Хуучин гэрээ»-ний грек орчуулга болох «Септуагинта»-г дагадаг юм. “Мөнх” гэж орчуулдаг нэр үг нь αἰών буюу монголчилсноор “эон” гэдэг.

Энэ нь еврей “улаам” гэдэг үгийн орчуулга. Өнгөрсөн балар цагийг харсан “улаам-аас”, мөн мэдэгдэхгүй ирээдүйг харсан “улаам-хүртэл” гэсэн еврей хэллэгүүд «Септуагинта»-д мөн «Шинэ гэрээ»-нд шууд грекжүүлсэн байдлаар гардаг (жишээ нь, Лук 1:70 ἀπ’ αἰῶνος; АБ: “эртнээс” ба Иуда 1:13 εἰς αἰῶνα; АБ: “үүрд”).

Гэтэл грек “эон” нь еврей “улаам” гэснээс зарим талаар илүү тодорхой болсон. «Шинэ гэрээ» нь «Хуучин гэрээ»-ний илчлэлтийг үргэлжлүүлэн тодруулдаг учиртай болохоор үүнд гайхах юм алга. Тухайлбал: эоний төгсгөл, дараагийн эон, олон тооны эонүүдийн тухай гардаг.


Манай геологчид “эон” гэдэг үгийг галиглан авч геологийн цаг тоололын хамгийн том нэгжийг нэрлэхэд хэрэглэдэг. “Эон” зайлшгүй цаг хугацааг заадаг үг учраас АБ-д “мөнх” биш “үе” гэж орчуулах нь олонтаа. Өөр арга байхгүй учраас тэр.



Хэд хэдэн жишээг авч үзье. Тэгэхдээ геологчдийн адил тухайн грек үгийг шууд галиглан авъя. Тэгэх нь ишлэлүүдийн анхны утгыг гаргахад тус болно. ¹

-- Дагалдагчид Есүсээс “Таны залрал болон **ҮЕИЙН [эоний] төгсгөлийн тэмдэг юу байх вэ?**” гэж асуудаг (Матай 24:3).

Хэрэв энэ ишлэлийг теологчдийн тайлбараар



буюу “хязгааргүй мөнх үргэлжлэх байдал” гэсэн хэллэгээр “орчуулж” үзвэл утгагүй юм гарч ирнэ.

Тухайлбал:

--Дагалдагчид Есүсээс “Таны залрал болон хязгааргүй мөнх үргэлжлэх байдлын [эоний]

1 Жич: Та өөрөө эон гэдэг үг бүхий ишлэлийг эндээс <https://www.blueletterbible.org/lexicon/g165/asv/mgnt/0-1/> ба эон гэснээс гарсан тэмдэг нэр αἰώνιος буюу *aionios*, код: G166) бүхий ишлэлийг эндээс <https://www.blueletterbible.org/lexicon/g166/asv/mgnt/0-1/> судалж болно.



төгсгөлийн тэмдэг юу байх вэ?” гэж асуусан бол үнэхээр болохгүй биз? Тийм учраас “эон” гэсэн үгийг “үе” гэж орчуулах нь зөв.

--Одоогийн эоноос гадна ирээдүйн эон гэж бий (“ирээдүйн мөнх” гэвэл утгагүй). Есүс иудейчүүдэд хэлэхдээ:

“Хүний Хүүгийн эсрэг үг хэлдэг хэн боловч уучлагдах болно. Харин Ариун Сүнсний эсрэг юм ярьдаг хэн боловч ЭНЭ ба ИРЭХ ҮЕД [эонд] ч уулагдахгүй” (Матай 12:31).

Мэдээж “энэ хязгааргүй мөнх үргэлжлэх байдал ба ирэх хязгааргүй мөнх үргэлжлэх байдал” гэвэл огт утгагүй хэрэг учраас яалт ч үгүй “мөнх” гэж өөр ишлэлд орчуулдаг “эон” гэсэн үгийг энд мөн “үе” гэж орчуулсан.

--"Эон" гэдэг грек үндсэн үгийг судлахаар бүр ч гайхалтай нэг мэдээлэл гарч ирнэ. Тухайлбал: Одоогийн эоний дараа ганц биш, ядаж хоёр ирээдүйн эон бий!

“Хязгааргүй мөнх үргэлжлэх байдал” үнэхээр олон тоогоор байх боломжгүй нь ойлгомжтой. Их Эзэний Паулаар бичүүлсэн дараах үгийг тунгаан бодоорой. Үүнд: **Ертөнцийн Эзэн-Эцэг “Христ Есүс дотор биднийг Түүнтэй хамт амилуулж, хамт тэнгэрлэг оршихуйд суулгасан нь Христ Есүс дотор бидэнд хандсан Түүний нигүүлслийн хэмжээлшгүй**




баялгийг ирэх ҮЕҮДЭД [зонүүдэд] үзүүлэхийн тулд юм" (Эфэс 2:7).

Одоогийн байдлаар бид сүнсээрээ Есүстэй дахин амилж Түүнтэй хамт хаан сэнтийд нь суусан. Гэхдээ энэ нь бүрэн биелэгдэх өдөр ирээгүй байна. Есүсийг ирж Өөрийн Биеэ шүүрэн авах үед (1 Тесалоник 4:14-18-г үзнэ үү) итгэгч бид нас барсан байвал биеэрээ дахин амилж, Түүнтэй хамт тэнгэр өөд явна.

Нас барж амжаагүй бол бие маань ганц хором дотор өөрчлөгдөн, бас үүлэн дунд Түүнтэй уулзаж хамт тэнгэр өөд явж үргэлж Түүнтэй хамт байх болно. Итгэгч бид Түүнтэй хамт хаан сэнтийд суух дуудлагатай гэж та бод доо!

“Үгүй ээ, би үүнд зохистой хүн биш ээ” гэж та бодож магад. Тийм шүү, үнэн. Яг тан шиг, над шиг зохисГҮЙ хүмүүс дээр Ертөнцийн Эзэн Өөрийнхөө хайр ивээлийн хэмжээлшгүй их баялгийг үзүүлэх гэж байна. Ирээдүйн эон үеүдийн турш!





--Өнгөрсөн, одоогийн, мөн ирээдүйн эонүүд тодорхой зорилготой болохыг Паул бичсэн байгаа. Даанч Ариун Библийн орчуулагч нар бусад орны орчуулгыг дагаад Паулын үгийг тэгэж ойлгогдохооргүй орчуулсан байна. Тухайлбал: "Энэ бүхэн бидний Эзэн Христ Есүсийн дотор Бурханы үйлдсэн мөнхийн зорилгын дагуу болж байна..." (Эфэс 3:11, АБ) "Мөнхийн зорилго" чухам юуг хэлдэг вэ?! Нэгэнт биелсэн зорилго өнгөрдөг учраас "мөнхийн" зорилго хэзээ ч биелэхгүй, мөнхөд байсаар л байх ёстой биш үү?

Дээрх ишлэийн грек эхийг шалгаад үг үгээр орчуулъя. Үүнд: "**Энэ бүхэн ЭОН ҮЕҮДийн зорилгын дагуу болж байна. Тэрхүү зорилгыг Тэрээр бидний Эзэн Христ Есүсийн дотор тавьсан...**" (Эфэс 3:11). Паул "мөнхийн зорилго"-ын тухай бичээгүй юм байна. Энэ утгагүй санагдам хэллэгийг тайлбарлахаар оролдох хэрэггүй гэсэн үг. Ертөнцийн Эзэн эонүүдэд тодорхой зорилго тавьсан

байгааг Паул бичжээ. Энэ бол маш ойлгомжтой бөгөөд гайхалтай үг!

THE EONIAN TIMES

God's Purpose in the Eons

Session 4

Eternity Past	Eon 1 Creation	Eon 2 Ignorance	Eon 3 Evil	Eon 4 The Kingdom	Eon 5 The New Creation	Eternity Future
<p>Timelessness</p> <p>The Son of God First of creation Colossians 1:15-17</p> <p>God all by Himself</p>	<p>Time begins</p> <p>The Son of God All things created through himself for him Colossians 1:16-17</p>	<p>Man falls into disobedience man made mortal Romans 5:12</p> <p>The seed of the woman will defeat the devil and abolish his work</p>	<p>Israel called to be God's holy nation, to rule and bless the world, but have been God repeatedly, hates Gentiles</p> <p>The seed of the woman born Galatians 3:28-29</p>	<p>Christ's millennial reign Revelation 20:1-6</p> <p>The former resurrection 1 Corinthians 15:20-28</p> <p>Israel's repentance Romans 11:13-15</p>	<p>God present with man on earth.</p> <p>No more tears no more sorrow, no sorrow, no pain, no sin Revelation 21:4</p>	<p>Triumphance God All in all Colossians 3:10</p> <p>Sacred Life in All Death Destroyed 1 Corinthians 15:54</p>



--“Эон үеүдийн эон үеүд” гэдэг сонирхолтой хэллэг ч бий (АБ: “үеийн үед”, “үүрд мөнх”). Жишээ нь, “**Цорын ганц мэргэн Бурханд, Есүс Христээр алдар нь үүрд мөнх [грек: эон үеүдийн эон үеүдэд] байх болтугай. Амен.**” (Ром 16:27).²

Энэ бол майхан сүм дэх "ариун газруудын ариун газар" (АБ: "ариунаас ариун газар") гэсэн хэллэгтэй төстэй бүтэц бүхий еврей хэллэг.



Майхан сүмийн бүх хэсэг ариун газар байсан боловч тэр доторх тасагт Ертөнцийн Эзэний Оршихуй байсан учраас “хамгаас ариун” гэж нэрлэдэг байв. Үүнчлэн "эонүүдийн эонүүд" гэдэг нь “бүх

эонүүдээс сайн сайхнаараа шалгарах эонүүд”-ийг хэлнэ.

Эдгээр сайхан эонд Их Эзэн Өөрөө энэ дэлхийг захирч, “Өөрийн нигүүлслийн хэмжээлшгүй баялгийг” улам илүү ихээр үзүүлэх болно (Эфэс

² Тус хэллэг мөн Галат 1:4; Филиппой 4:20; 1 Тимот 1:17; 2 Тимот 4:18; Еврей 13:21; 1 Петр 4:11, 5:11; Илчлэлт 1:6,18; 4:9; 5:13; 7:12; 10:6; 11:15; 14:11; 15:7; 19:3; 20:10; 22:5 зэрэг ишлэлд бий.



2:7). Тэр үед л Бүтээгч Эзэнд бүх хүмүүсээс хүндлэл ба алдар ирэх болно. Өнөөдөр даан ч тийм биш. Ертөнцийн Эзэний хуанлид ирээдүйн ганц биш, ядаж хоёр эон үе товлогдсон байгаа нь мөн энэ хэллэг харуулж байна!

“Мөнх” гэсэн үгийг “хязгааргүй мөнх үргэлжлэх байдал” гэж ойлгох нь тайлшгүй асуудал гаргадгийг дараах хэллэг харуулна. Үүнд:


- “Хязгааргүй мөнх үргэлжлэх байдал”-д нэгэнт эхлэл үгүй юм бол “мөнх цагаас өмнө” гэсэн хэллэг утгагүй (Тит 1:2).
- “Хязгааргүй мөнх үргэлжлэх байдал” цаг хугацаанаас ангид байвал “мөнхөд үргэлжлэх байдлын төгсгөл”, “ирэх мөнхөд үргэлжлэх байдал” зэрэг дотроо зөрчилдөөнтэй хэллэг утгагүй.
- Ганц нэг хязгааргүй мөнх үргэлжлэх байдал байх боломжтой. Тэгвэл Библид яагаад “энэ эон”, “тэр эон”, бүр олон тооны “эонүүд”-ын тухай гардаг вэ?

Библи нэгэнт Ертөнцийн Эзэний Үг учраас дотроо зөрчилдөөнтэй байх боломжгүй. Эдгээр асуудлыг тайлах ганц арга зам бол Библийн Үгийг биш, теологчдын гаргасан тайлбарыг бүрмөсөн хаяхад оршино. “Хүн бүр худалч байсан ч, Бурхан үнэн байг” (Ром 3:4).



Дээрх бүхнийг дүгнэж хэлэхэд, «Шинэ гэрээ»-ний “эон” гэсэн грек үгийг судлахад утга нь “хязгааргүй мөнх үргэлжлэх байдал” юмуу “хэм хэмжээгүй, хэзээ ч дуусашгүй, цагаас гадуурх байдал” биш, харин тодорхой эхлэл ба төгсгөл бүхий хугацааг хэлэх нь тод харагдана. Эон үе удаан үргэлжлэх боловч хэзээ нэгэн цагт заавал дуусах болно. Тэгэхэд ганц биш, хэд хэдэн тийм дараалсан үеүд байдаг. Их Эзэн эон үеүдийг тодорхой зорилготой товлосон бөгөөд тэдгээр эонүүдийн турш төлөвлөгөөгөө явуулдаг.

Энэ дүгнэлтэд олон эрдэмтэн санаа нийлдэг.³ Ганц жишээ өгөхөд, «Шинэ Гэрээний үгийг судалсан нь» гэдэг тайлбарынхаа 3-р ботид Нью Йорк хотын Union Theological Seminary дахь профессор байсан Marvin Vincent 2 Тесалоник 1:9-д гардаг “мөнх сүйрэл” тухай тэмдэглэлтэд тайлбарлахдаа,



3 Хэд хэдэн эрдэмтэд энэ сэдвээр үг бичсэн нь: <https://www.gods-kingdom-ministries.net/teachings/articles-and-poetry/the-meaning-of-eternal-and-everlasting/>



“Эон” гэдэг бол урт богино хугацаатай, эхлэл ба төгсгөл бүхий цаг үе. Аристотлийн дагуу “Хэн нэгний амь насыг бүхлээр нь агуулсан хугацааг тухайн хүний эон гэж нэрлэдэг.”

Тэгвэл “эон” олон тохиолдолд хүний амь насыг хэлдэг. Гэвч энэ үгийн утга хүний амь насанд хязгаарлагдахгүй ...

...бас үндэстний амь нас, хэрээний амь нас, царс модны амь насыг хэлж болно. Эоний хугацаа нь яригдаж буй зүйлээс нь шалтгаална. ... Ямартай ч үндсийн утгын хувьд “эон” ба үүнээс гаралтай тэмдэг нэрэнд үргэлж цаг хугацааны санаа бий, харин дуусашгүй мөнх үргэлжлэх санаа байхгүй... Хэзээд цаг хугацаанд баригдсан зүйлд хэрэглэгддэг үг дотроо эцэс төгсгөлгүй гэсэн санааг агуулах боломжгүй. Ертөнцийн Эзэнийг “эоний” чанартай гэснийг хүртэл бид заавал “дуусашгүй мөнх” гэж орчуулах албагүй. Учир нь энэ хэллэг Түүний үхэшгүйг онцлохоос илүү Түүний цаг хугацаа захирдагийг заасан үг байж болно” гэж бичсэн.

Теологчдын гаргасан тодорхойлолтыг орхих арга замыг олон улсын орчуулагчид, мөн Ариун Библийн орчуулагчид олон ишлэл дээр сонгож, “эон” гэдэг үгийг “үе” гэж дөхөн орчуулсан юм. Энэ л замаар утгагүй орчуулгаас зайлсхийх



боломжтой учраас тэр. Гэтэл олон тоогоор гарсан “эон” ба “эонүүдийн эон” мэтийн сонирхолтой хэллэгийг ер нь зөв орчуулдаггүй. Улмаар, “эон” гэсэн үгийг заримдаа бүр өөрөөр орчуулсан байдаг.

Жишээ нь,

- “ертөнц”(Еврей 1:2; 11:3-д “эонүүдийг бүтээсэн”; Эфэс 6:12 “энэхүү харанхуй эон”),
- “дэлхий” (Матай 13:22, “энэ эоний зовнил”),
- “хэзээ ч үгүй” (Марк 3:29 “эоний туршид уучлал авахгүй”; Иохан 4:14 “эоний туршид цангахгүй”),
- “заншил” (АБ 2004), “замнал” (АБ 2013; Эфэс 2:2 “энэ ертөнцийн эон”),
- “мөнхийн” (Эфэс 3:11 “эонүүдийн зорилго”).

Ийм олон янзын орчуулга хэрхэн урт удаан цаг хугацааг заасан үгийг зөв орчуулж чадах вэ дээ? Нэгэнт “эон” гэдэг нь “урт удаан хугацаат үе” гэсэн утгатай учраас энэ үг гарах бүх тохиолдолд адилхан галиглаад “эон” буюу “эон үе”, олон тоогоор гарахад “эонүүд” эсвэл “эон үеүд” зэрэг орчуулмаар байна.

“Эон” гэсний утга тодорхой болсон байхад тус



нэр үгнээс гарсан тэмдэг нэрийн утга мөн адил тодорхой юм. Тэмдэг нэр зайлшгүй нэр үгийнхээ утгыг дагадаг учраас тэр. Энэ шалтгаанаар монгол нэр үг, тэмдэг нэр хоёр олон тохиолдолд яг адилхан хэлбэртэй.⁴ Ямартай ч тэмдэг нэр хэзээ ч холбосон нэр үгийнхээ утгаас давж хэтрэхгүй. Αἰώνιος гэдэг нэр тэмдэг тэгвэл “эон үеийн” гэж ойлгогдож болно. Библи орчуулагч нар энэ үгийг ихэвчлэн “мөнх” эсвэл “үүрд” гэж орчуулдаг.

Еврей, грек эх үгсийг оновчтой орчуулахын тулд Библи орчуулагчид монгол толь бичиг эргүүлэх үе зайлшгүй гардаг. Тэгвэл “мөнх” гэсэн үгийн, теологичдийн тайлбар ороогүй цэвэр монгол утгыг толь бичгээс лавлая.

Mongoltoli.mn-ийн дагуу “мөнх” гэдэг нь “юмс үзэгдлийн хувирч өөрчлөгдөхгүй, харьцангуй бат бэх орших чанар, үүрд, эгнэгт” гэсэн утгатай. Үүний жишээд, “мөнх зул”, “мөнх ногоон ургамал”, “мөнх сарьдаг”, “мөнх цэвдэг”, “мөнх өвс” гэж тоочсон байна. Энэ бүх зүйл урт удаан

4 Хэдэн жишээ өгөхөд: Хүний том, жижгийг хэмжихэд том биетэй хүн, жижиг биетэй хүн бий. Тийн ялгал тавьсан “том, жижиг” нэр үгээр орсон, харин биеийг тодорхойлсон “том, жижиг” бол тэмдэг нэрээр орсон. “Монгол” гэдэг нь улс юмуу үндэстний нэр байж болно, эсвэл тухайн улсын хэл, дээр, гэр зэргийг нь тодорхойлох тэмдэг нэр ч байж болно. Олон тэмдэг нэр -тай⁴ гэсэн нөхцөл залгасан нэр үгээр бүрддэг (гайхамшигтай, сэжигтэй).



үргэлжилсэн ч хэзээ нэгэн цагт дуусан өнгөрөх тавилантай.



Үүнээс
харахад
МОНГОЛ
“МӨНХ” яг л
энд авч
үзсэн еврей
ба грек үгс
шиг урт
удаан
үргэлжилсэн
ч хэзээ нэгэн

цагт дуусах хугацааны чанарыг заана. Тэгвэл Библи уншихаар “мөнх” гэдэг үгийг яг л монгол утгаар нь ойлгох ёстой гэсэн үг.

Дээрх бүх ишлэл “төгсөшгүй мөнх”-ийг биш, харин төгсгөл нь харагдахгүй удаан хугацааг хэлсэн байдгийг нэгэнт ойлгосон юм бол Ертөнцийн Эзэн “мөнхөд...тэгээд дараа нь” гэсэн гайхалтай төлөвлөгөөтэй болохыг харж эхэлнэ.

Энэ талаар дараагийн нийтлэлд авч үзэх болно.



Хэрэглэсэн эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон.

---Монгол Хэлний Их Тайлбар Толь (2016). mongoltoli.mn

---Moulton, J.H. & Milligan, G. (1929). *The vocabulary of the Greek Testament: Illustrated from the papyri and other non-literary sources*. London: Hodder & Stoughton.

<https://archive.org/details/vocabularyofgree00mouluoft/page/204/mode/2up> (p. 16)

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org

---Vincent, M.R. (1887). Word studies in the New Testament, Volume 3 & 4. <https://www.hopefaithprayer.com/books/Word-Studies-in-the-New-Testament-Vol-3&4-Marvin-R-Vincent.pdf>